БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/54/НА-СТА-ТШЗ**


Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 92921881 Цахим хаяг:erkebulankh@ audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....12
3. Аудитын тайлан....12
3.1 Ерөнхий зүйл .... 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... 13
3.4 Материаллаг байдал .... 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.... 15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .... 16
3.8 Аудитын гол асуудал .... 16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.... 16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.... 17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.... 17
4. Аудитын илрүүлэлт ....17
4.1 Залруулсан алдаа.... 17
4.2 Төлбөрийн акт.... 17
Байхгүй ....**Error! Bookmark not defined.**
4.3 Албан шаардлага .... 17
4.4 Зөвлөмж .... 17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.25 № 211

танай_____________-ны № ______________-т

БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Х.БАЯНБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,164,184.00** | **2,201,537.70** |
| **33** | **АВЛАГА** | 526,689.00 | 561,142.70 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 526,689.00 | 526,689.00 |
| **335** | **Бусад авлага** | - | 34,453.70 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 34,453.70 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,637,495.00 | 1,640,395.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 1,637,495.00 | 1,640,395.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 185,000.00 | 185,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,161,816.00 | 1,164,716.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 290,679.00 | 290,679.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,344,482,344.08** | **3,288,527,041.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,344,482,344.08 | 3,288,527,041.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,343,516,344.08 | 3,287,561,041.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 445,479,490.00 | 449,479,490.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -53,818,629.72 | -63,826,959.60 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 167,673,700.00 | 167,673,700.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -156,610,889.51 | -158,929,094.57 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,129,902.00 | 64,329,702.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51,057,684.89 | -56,872,794.46 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 47,720,786.00 | 42,140,298.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,387,983.73 | -34,277,533.77 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,062,995,093.00 | 4,134,548,921.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,138,607,439.07 | -1,256,704,687.49 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 966,000.00 | 966,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,683,400.00 | 1,683,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,683,400.00) | (1,683,400.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 966,000.00 | 966,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,346,646,528.08** | **3,290,728,578.81** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **354,100.00** | **333,607.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 354,100.00 | 333,607.00 |
| **413** | **Өглөг** | 354,100.00 | 333,607.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 354,100.00 | 333,607.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 354,100.00 | 333,607.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,346,292,428.08** | **3,290,394,971.81** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,346,292,428.08 | 3,290,394,971.81 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 820,625,165.00 | 820,625,165.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 820,625,165.00 | 820,625,165.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,644,172,435.06 | 1,588,274,978.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,644,172,435.06 | 1,644,172,435.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -55,897,456.27 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 881,494,828.02 | 881,494,828.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,346,646,528.08** | **3,290,728,578.81** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,921,172,464.00** | **435,653,268.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,921,172,464.00** | **434,121,728.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,625,988,564.00 | 79,273,628.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,617,213,692.00 | 79,273,628.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,617,213,692.00 | 79,273,628.00 |
| 120009 | Бусад орлого | 8,774,872.00 | 00.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 295,183,900.00 | 354,848,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 295,183,900.00 | 354,848,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **-** | **1,531,540.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,531,540.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,531,540.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **458,757,582.44** | **491,550,724.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **458,757,582.44** | **491,550,724.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 454,314,382.44 | 444,521,324.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 229,345,978.00 | 225,154,446.30 |
| 210101 | Үндсэн цалин | 187,419,752.00 | 151,279,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 39,568,950.00 | 49,342,578.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 2,357,276.00 | 24,532,068.30 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,919,500.00 | 30,400,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,721,646.86 | 21,086,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,269,067.63 | 2,251,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,936,853.73 | 1,801,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 453,798.53 | 437,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,538,133.25 | 4,823,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,784,943.00 | 12,777,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,059,900.00 | 1,588,600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,725,043.00 | 11,189,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,793,108.00 | 7,205,010.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,428,300.00 | 1,908,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,843,808.00 | 4,094,460.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,496,000.00 | 1,137,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,000.00 | 63,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 445,800.00 | 467,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 445,800.00 | 467,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 636,900.00 | 1,115,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 25,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 636,900.00 | 1,089,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,390,000.00 | 2,144,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,390,000.00 | 2,144,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,941,500.00 | 11,525,157.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 580,900.00 | 10,610,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 416,900.00 | 302,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,300.00 | 5,257.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 211,900.00 | 168,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,600.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 438,100.00 | 266,700.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 89,800.00 | 58,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 163,056,653.44 | 153,730,610.97 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,829,600.00 | 14,566,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 355,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 154,727,053.44 | 138,808,930.97 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,443,200.00 | 47,029,400.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 45,805,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 45,805,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,443,200.00 | 1,224,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,443,200.00 | 1,224,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **2,462,414,881.56** | **(55,897,456.27)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **2,462,414,881.56** | **(55,897,456.27)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 820,625,165.00 | 881,494,828.02 | 1,644,172,435.06 | 3,346,292,428.08 |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 820,625,165.00 | 881,494,828.02 | 1,644,172,435.06 | 3,346,292,428.08 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 820,625,165.00 | 881,494,828.02 | 1,644,172,435.06 | 3,346,292,428.08 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| Тайлант үеийн үр дүн | | | -55,897,456.27 | -55,897,456.27 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **820,625,165.00** | **881,494,828.02** | **1,588,274,978.79** | **3,290,394,971.81** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **295,183,900.00** | **356,379,640.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **295,183,900.00** | **356,379,640.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 295,183,900.00 | 354,848,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 295183900.00 | 354848100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,531,540.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,531,540.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **302,998,772.00** | **352,799,640.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **302,998,772.00** | **352,799,640.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **298,555,572.00** | **305,770,240.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,473,789.00 | 225,188,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 156,101,489.00 | 150,879,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 50,807,600.00 | 46,367,979.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,564,700.00 | 27,941,121.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,119,475.00 | 30,400,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,314,400.00 | 21,392,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,243,700.00 | 2,251,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,794,800.00 | 1,801,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 722,400.00 | 450,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,044,175.00 | 4,503,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,187,300.00 | 12,294,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,111,000.00 | 1,104,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,076,300.00 | 11,189,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,749,508.00 | 7,613,560.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,673,800.00 | 2,292,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,665,808.00 | 4,096,960.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,384,900.00 | 1,135,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,000.00 | 89,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 445,800.00 | 423,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 445,800.00 | 423,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 636,900.00 | 1,157,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 25,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 636,900.00 | 1,131,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,120,000.00 | 2,144,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,120,000.00 | 2,144,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,593,200.00 | 11,641,300.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 580,900.00 | 10,623,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 416,900.00 | 302,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 108,300.00 | 10,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 211,900.00 | 176,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 95,600.00 | 75,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 84,000.00 | 355,200.00 |
| 210807 | Газрын төлбөр | 45,600.00 | 37,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 50,000.00 | 61,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,229,600.00 | 14,905,880.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,829,600.00 | 14,566,180.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 339,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,443,200.00** | **47,029,400.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 45,805,400.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 45,805,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,443,200.00 | 1,224,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,443,200.00 | 1,224,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(7,814,872.00)** | **3,580,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **960,000.00** | **3,580,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **960,000.00** | **3,580,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 960,000.00 | 3,580,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 960,000.00 | 3,580,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(960,000.00)** | **(3,580,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (8,774,872.00) | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 354,848,100 | 353,624,100 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 354,848,100 | 353,624,100 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 309,042,700 | 307,818,700 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 225,188,900 | 225,188,900 |
| 210101 | Үндсэн цалин | 150,879,800 | 150,879,800 |
| 210102 | Нэмэгдэл | 45,995,100 | 46,367,979 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,314,000 | 27,941,121 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,400,500 | 30,400,500 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,392,800 | 21,392,800 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,251,900 | 2,251,900 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,801,600 | 1,801,600 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 450,400 | 450,400 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,503,800 | 4,503,800 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,116,900 | 12,294,000 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,104,800 | 1,104,800 |
| 210302 | Түлш, халаалт | 11,012,100 | 11,189,200 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,562,700 | 7,613,560 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,183,700 | 2,292,000 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,155,600 | 4,096,960 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,135,400 | 1,135,400 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 88,000 | 89,200 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000 | 423,700 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000 | 423,700 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,131,700 | 1,157,500 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 25,800 |
| 210604 | Урсгал засвар | 1,131,700 | 1,131,700 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,669,200 | 2,144,900 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,669,200 | 2,144,900 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,275,800 | 12,221,300 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,150,400 | 11,123,400 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200 | 302,200 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300 | 90,300 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 176,900 | 176,900 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000 | 75,000 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 378,700 | 355,200 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300 | 37,300 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 65,000 | 61,000 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,240,000 | 16,374,340 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,740,000 | 16,034,640 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000 | 339,700 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 45,805,400 | 45,805,400 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,805,400 | 45,805,400 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 45,805,400 | 45,805,400 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 354,848,100 | 353,624,100 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 354,848,100 | 353,624,100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 354,848,100 | 353,624,100 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.0 | 1.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 23.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 7.0 | 7.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.0 | 9.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.0 | 7.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **23.0** | **23.0** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.0 | 9.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8.0 | 8.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.0 | 6.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,531,540.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,531,540.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,531,540.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1531540.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1,531,540.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1531540.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1531540.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,531,540.00 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 3/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Буянт сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго нь Мэдлэг чадвар, хариуцлага, хяналтыг эрхэмлэн төлөвшиж, төрийн хууль тогтоомж олон нийтийн оролцоо нь дээр суурилсан иргэдээ угтан үйлчлэх шуурхай үйлчилгээг хангасан төрийн захиргааны чадварлаг байгууллага болохыг эрмэлзэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Буянт сумын Засаг даргын тамгын газарт дотоод аудитын нэгжгүй ба тус тамгын газрын тодорхойлсон эрсдэлийг нэгтгэн, байгууллагын эрсдэлийн үнэлгээг тогтоож, жилийн тайланг аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлдэг байна.

Тус газарт 2021 онд дотоод аудитын шалгалт ирээгүй бусад эрх бүхий байгууллагуудаас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 458.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55.9 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 526.7 | 561.1 | 34.4 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 1637.5 | 1640.4 | 2.9 |
| Үндсэн хөрөнгө | 3344482.3 | 3288527.0 | -55955.3 |
| **Нийт хөрөнгө** | **3346646.5** | **3290728.5** | **-55918.0** |
| Өр төлбөр | 354.1 | 333.6 | -20.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3346292.4 | 3290395.0 | -55897.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3346292.4** | **3290395.0** | **-55897.4** |

Мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй, авлагын дансны үлдэгдэл 0.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1.6 сая төгрөг байна. Тайлант онд 11.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 11.2 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3288.5 сая төгрөг болж 55.9 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 3.6 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 79.3 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авч, Буянт сумын ИТХ-ын 2021 оны 30 дугаар тогтоолын дагуу 5.7 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хасаж, үндсэн хөрөнгөнд 138.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр данс оны эцэст 0.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3290.4 сая төгрөг болж 55.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -55.9 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 435.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 2487.1 сая төгрөгөөр буюу нэг дахин буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс буурсан шалтгаан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал 491.5 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 32.8 сая төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Хангамжийн бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар 2021 оны анх батлагдсан төсөв 356.4 сая төгрөг, тодотгосон төсөв 354.5 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 1.9 сая төгрөгөөр буурсан байна. Бараа үйлчилгээний бусад зардлыг 1.9 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 354.8 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 353.6 сая төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлтээс 1.2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нийт төсвийн 63.7 хувийг цалин, 8.6 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 3.5 хувийг тогтмол зардал, 2.1 хувийг хангамж бараа материалын зардал, 0.1 хувийг нормативт зардал, 0.2 хувийг эд хогшил худалдан авах, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 0.5 хувийг томилолт, зочны зардал, 3.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, 4.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 13.2 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын тамгын газраас 1.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авчээ. Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 1.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Буянт сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 353.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 2.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 353.6 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 353.6 сая төгрөгийн 119 мэдээллийг хугацаандаа байршуулсан байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 44.0 сая төгрөгийн 3 гүйлгээ гарсныг мэдээлээгүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд тайлант хугацаанд оруулбал мэдээллээс сар, тухай бүр оруулах мэдээллээс 2020 оны 12 дугаар сарын төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллүүд, нийтдээ 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд 1 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг Буянт сумын ЗДТГ-ын 2021.11.24-ний №3/206 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 126.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.9 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 123.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 2.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв. Үүнд:

1. Буянт сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр нийт 353.6 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтад хамаарах үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад батлагдсан төсвийн 10 хувь 2.9 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш 44.0 сая төгрөгийн 3 гүйлгээ гарсныг мэдээлээгүй орхигдуулсан байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын холбогдох заалтуудыг мөрдөж цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.

***2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1 <u>Илрүүлэлт:</u>*

Буянт сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд шуудан холбоо, интернэт, бичиг хэрэг, түлш халаалт, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардлын тооцоогоор гарсан нийт 33.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 20.2.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж зарлагын гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгаж ажиллах, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Буянт сумын Засаг даргын тамгын газар | 3 | 80.6 | | | | | 1 | 2.9 | 2 | 77.7 |
| **Нийт дүн** | | **3** | **80.6** | | | | | **1** | **2.9** | **2** | **77.7** |